Журмын 10 дугаар хавсралт

# ХҮНИЙ НӨӨЦИЙГ ЧАДАВХЖУУЛАХ, ТОГТВОР СУУРЬШИЛТАЙ АЖИЛЛУУЛАХ ТАЛААР БАЙГУУЛЛАГЫН 2019 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТУСГАГДСАН ЗОРИЛТЫН БИЕЛЭЛТ

НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР

ОГНОО: 2019.12.25

| Зорилт | № | Үйл ажиллагаа | Шалгуур үзүүлэлт | Зорилтот түвшин (Тоо хэмжээ, хувь) | Хүрсэн түвшин (Хэрэгжилт-ийн хувь, тоо хэмжээ) | Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр гүйцэтгэлээр (мян.төг) | Тайлбар |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| 1. Хүний нөөцийг чадавхжуу-лах | 1 | Албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан гадаад, дотоодын сургалт | Дотоод сургалтын тоо | 5-аас дээш | 25 удаа 100% | - | Тайлангийн хугацаанд Мандах дээд сургуулийн магистрт 1, Сан дээд сургуулийн нягтлан бодох бүртгэл 1, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн бизнесийн удирдлагын магистраар 1, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтад мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн ангид 1, МУИС-н магистрт 1 нийт 5 албан хаагч суралцаж байна.<br>Удирдлагын академийн пүрэвийн гаригийн ангид 1, Роял академийн магистрт 1, МУИС-н магистрт 1 нийт 3 албан хаагч суралцан төгссөн. Үйлчилгээний ажилтны мэргэжлийн зэрэг болон үнэмлэх олгох сургалтанд 20 үйлчилгээний ажилтан хамрагдаж 3 дугаар зэрэгтэй болсон.<br>Тайлант хугацаанд нийт ажилтан, албан хаагчдад 25 удаагийн сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 535 ажилтан, албан хаагч хамрагдсан. Зохион байгуулагдсан сургалтын чиглэлүүд:<br>1.Хувь хүний харилцаа хандлага, ёс зүй, ажлын цаг ашиглалтын чиглэлээр 5 сургалт:<br>- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн төвтэй хамтран 2 удаагийн “Хувь хүний хөгжил” , “Ажлын цаг ашиглалт, ажлын байрны сэтгэл зүй, эмх цэгц” сэдэвт сургалтуудад үйлчилгээний 80 ажилтан;<br>- Байгууллагын соёл, ажилтны харилцаа, хандлага” сэдэвт сургалтанд НЗЗ-ны 1, 2-р |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 600.0 ₮<br>1.800.0 ₮<br>200.000₮ | байрны 33 үйлчилгээний ажилтнууд;<br>- Ахмадын зөвлөлтэй хамтран “Ажлын байрны цэвэрлэгээ үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэх, үйлчилгээний ажилтны ёс зүйг хангаж ажиллах нь” сэдэвт сургалтанд 27 ажилтан, албан хаагч;<br>2. Мэргэжлийн зэрэг олгох, ур чадвар нэмэгдүүлэх, ажлын байрны давтан сургалтын чиглэлээр 5 сургалт:<br>- Монголын Зочид буудлын холбоотой хамтран зохион байгуулсан зөөгчийн ур чадвар нэмэгдүүлэх сургалтанд 22 албан хаагч;<br>- Төр засгийн үйлчилгээ эрхлэх газрын үйлчилгээний ажилтны мэргэжлийн зэрэг болон үнэмлэх олгох сургалтанд 20 үйлчилгээний ажилтан хамрагдаж 3-р зэрэгтэй болсон;<br>- Монголын хоол үйлдвэрлэл, үйлчилгээний мэргэжлийн боловсролын академитай хамтран зохион байгуулсан тогооч нарын ажлын байрны давтан сургалтанд 20 ажилтан, албан хаагч;<br>- МЗБХолбоо, НАЖГ-аас зохион байгуулсан баристагийн сургалтанд 1 зөөгч;<br>- НАЖГ-аас зохион байгуулсан “Угтах үйлчилгээний стандарт” сургалтанд 1 угтах үйлчилгээний ажилтанг;<br>3.Ажлын туршлага солилцох ажлын чиглэлээр 2 сургалт:<br>- НЗЗ-ны байруудын үйлчилгээний ажилтнуудын багийн ахлагч нарын дунд ажлын туршлага солилцуулах сургалтанд 13 ажилтан;<br>- Төр, засгийн үйлчилгээ эрхлэх газар болон 21 аймгийн нийтлэг үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг мэргэшүүлэх сургалтанд захиргааны 3 албан хаагч;<br>4.Ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр 12 сургалт :<br>- Ажилтан, албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх чиглэлээр:<br>- НАГ-тай хамтран зохион байгуулсан “Баримт бичиг боловсруулалт, албан хэрэг хөтлөлтийн стандарт” сургалтанд ЗСХ-ийн 37 албан хаагч;<br>- “Архив, албан хэрэг хөтлөлтийн ерөнхий |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 600.0 ₮ | ойлголт" сэдэвт сургалтанд ЗСХ-ийн 29 албан хаагч;<br>- ОУ-ын Хүний нөөцийн хөгжлийн академитай хамтран зохион байгуулсан "Удирдахуйн ухаан" сэдэвт сургалтанд байр хариуцсан менежерүүд;<br>- Төрийн Албаны зөвлөлтэй хамтран зохион байгуулсан Төрийн албаны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн талаар сургалтанд ЗСХ-н 34 албан хаагч;<br>- Нийслэлийн мэдээлэл, технологийн газартай хамтран "Мэдээллийн аюулгүй байдал" сэдэвт сургалтанд ЗСХ-ийн 29 албан хаагч;<br>- Хэл зүйн ухааны доктор Ж.Ганбаатар "Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь"-ийг албан хаагчдад таниулах болон зөв бичих дүрэмд орсон нэмэлт өөрчлөлттэй холбоотой мэдээлэл өгөх сургалтанд ЗСХ-ийн 30 албан хаагч;<br>- Сангийн яамнаас зохион байгуулсан "Ерөнхий гэрээний журмаар худалдан авах ажиллагааг зохион байгуулах нь" сэдэвт сургалтанд ЗСХ-ийн 2 албан хаагч;<br>- Нийслэлийн Өмч, ашиглалтын удирдлагын газрын мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн Б.Мөнхбаатар "Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгөний орлого, зарлагын мэдээлэл оруулах нь" сэдэвт сургалтанд ЗСХ-ийн 17 албан хаагч;<br>- Байгууллагын цэвэрлэгээ үйлчилгээний стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалтанд байр хариуцсан 9 менежер;<br>- НАЖГ-аас зохион байгуулсан менежерүүдийн сургалтанд;<br>- НЗЗ-ны 2, 4 дүгээр байр хариуцсан менежер нарын зохион байгуулсан "Ажлын байрны цэвэрлэгээ, үйлчилгээний стандартыг дагаж мөрдөх" сэдэвт сургалтанд 30 албан хаагч;<br>- Нийслэлийн Онцгой байдлын газраас гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулийн хүрээнд цэргийн хэргийн мэдлэг олгох, жагсаалын бэлтгэл хангуулах сургалтанд 38 ажилтан, албан хаагч;<br>- ШУТИС-ын эрүүл мэндийн төвтэй хамтран |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 100.0 ₮ | “Ажлын байрны эрүүл ахуй, цэвэрлэгээ, халдваргүйжүүлэлтийн бодисыг зөв найруулж хэрэглэх нь” сэдэвт сургалтанд 40 ажилтан, албан хаагч;<br>Тайлант хугацаанд нийт ажилтан, албан хаагчдад 7 удаа мэдээллийн цагийг зохион байгуулж нийт албан хаагчдын 95 хувь хамрагдсан.<br>Мэдээллийн цагаар:<br>- БСШУЯ, биеийн тамир спортын бодлого төлөвлөлтийн газрын ахлах мэргэжилтэн Ж.Тунгалаг “Дасгал хөдөлгөөн-эрүүл аж төрөхүй” сэдвээр, ОУ-ын Хүний нөөцийн хөгжлийн академийн захирал, хүний нөөцийн мэргэшсэн зөвлөх Н.Амаржаргал “Биеэ зөв авч явах хувийн соёл, эрүүл сэтгэлгээ, зөв хандлагатай, өндөр бүтээмжтэй ажиллаж амьдрах ухаан” сэдвээр мэдээлэлийг нийт ажилтан, албан хаагчдад;<br>- НОБГ-ын сургалт, сурталчилгаа, урьдчилсан сэргийлэх асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, дэд хурандаа Б.Чинбат “Гамшгаас хамгаалах менежментийн тогтоолцоо, гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах арга хэмжээ” сэдвээр;<br>- “Төгс баян хүрээ” ХХК-ны захирал Х.Баянхангай “Ажлын байрны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” сэдвээр;<br>- ОУ-ын Улаанбаатар их сургуулийн Гэр бүл судлалын хүрээлэнгийн тэнхмийн эрхлэгч, доктор, дэд профессор Б.Оюун-Эрдэнэ “Хүүхдийн хүмүүжилд эцэг, эхийн оролцоо” сэдвээр нийт ажилтан албан хаагчдад мэдээлэл хийлээ.<br>- Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын сургалт, олон нийттэй харилцах хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Болормаа “Эрүүл мэндийн даатгалын хууль түүний үйлчлэл” сэдвээр нийт ажилтан албан хаагчдад мэдээлэл хийлээ.<br>- МУ-ын Засгийн газрын 2018 оны “Түүхий нүүрс хэрэглэхийг хориглох тухай” 62 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Агаарын бохирдолтой тэмцэх газрын ахлах мэргэжилтэн Г.Даваажаргал сайжруулсан |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | шахмал түлшний хэрэглээ, нийлүүлэлтийн талаар, “Онон” сантай хамтран нийгмийн эрүүл мэндийн ажилтан М.Мэндбаяр “Артерийн даралт ихсэлт, түүний эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх”, “Стресс менежмент” сэдвээр, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэстэй хамтран тус хэлтсийн ахлах мэргэжилтэн, хошууч Э.Баярбаясгалан “Зөрчлийн тухай хууль”-ийн талаар нийт ажилтан албан хаагчдад мэдээлэл хийлээ.<br>- “Ди Жи Би” ХХК эм ханган нийлүүлэх төвийн эмч Б.Мөрөн “Томуу, томуу төст, халдварт өвчнөөс урьдчлан сэргийлэх, эмийн зохистой хэрэглээ” сэдвээр, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ахлах дэслэгч Б.Нямсүрэн “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” |
| | | | Албан хаагчдын хамрагдсан байдал | 80 хувиас дээш | 100 % | 3.300.0 ₮ | • Тайлант хугацаанд ажилтан, албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх сургалтанд давхардсан тоогоор 535 ажилтан албан хаагчид хамрагдсан байна.<br>• 3 ажилтан, албан хаагч хувийн зардлаараа магистрт суралцан төгссөн бөгөөд 5 албан хаагч хувийн зардлаараа магистрт суралцаж байна.<br>• Үйлчилгээний ажилтны мэргэжлийн зэрэг болон үнэмлэх олгох сургалтанд 20 үйлчилгээний ажилтан хамрагдаж 3 дугаар зэрэгтэй болсон. |
| | | | Гадаад сургалтанд албан хаагчдын хамрагдсан байдал | - | - | - | - |
| | 2 | Мэргэшсэн, туршлагатай хүний нөөцийг бүрдүүлэх | 3 болон түүнээс дээш жил ажилласан мэргэшсэн боловсон хүчний үзүүлэлт | 70 хувиас дээш | 80% | | Тус байгууллага нь олон чиглэлийн үйлчилгээг эрхэлдэг тул олон мэргэжлийн ажилтан албан хаагчид байдаг. Одоогийн байдлаар мэргэшсэн нягтлан бодогч 2, ахлах зэрэгтэй эмч 1, Зоогийн газарт 1-3 дугаар зэрэгтэй тогооч 12, 3-р зэрэгтэй үйлчилгээний ажилтан 40 ажиллаж байна. 262 ажилтан, албан хаагчдын 80 хувь нь 3 болон түүнээс дээш жил тогтвор суурьшилтай ажиллаж байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хэсгийн дундаж: | | | | 93,3 % | 3.300.0 ₮ | |
| 2.Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах | 3 | Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх | Шагнал, урамшуулалд хамрагдсан албан хаагчдын тоо | Гүйцэтгэл-ээр | 289 ажилтан, албан хаагч 100% | 317,952,2 ₮ | Тайлант хугацаанд давхардсан тоогоор 318 ажилтан, албан хаагчдад 317,952,253 төгрөгийн урамшуулал олгосон байна. |
| | | | Албан хаагчдын үйл ажиллагааны үнэлгээ, ажилласан жил, ур чадварыг харгалзан олгох нэмэгдэл, зэрэг дэв, шатлал, ахиулах | Гүйцэтгэл-ээр | 289 ажилтан албан хаагч 100% | 296,840,9 ₮ | Тайлант хугацаанд давхардсан тоогоор 318 ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдэлд 291,826,791, зэргийн нэмэгдэлд 5,014,165 төгрөгийг зарцуулсан байна. |
| | 4 | Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцлийг бүрдүүлсэн байдал | Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулга | Сэтгэл ханамж 80 хувиас дээш | 85% | 300,000 ₮ | “Таныг сонсъё” аяны хүрээнд Байгууллагын үйл ажиллагаа, ажилтан, албан хаагчдын ажлын байрны нөхцөл байдлын талаар сэтгэл ханамжийн судалгааг НЗЗ-ны байруудад байрлаж байгаа ажилтан, албан хаагчдаас цахим хэлбэрээр, НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдаас цаасаар сэтгэл ханамжийн судалгааг авсан. Тус судалгаанд 39 байгууллагын болон НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа 683 ажилтан, албан хаагч хамрагдаж, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн, өрөө тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ, зоогийн газрын хоолны нэр төрөл, амт чанар, үйлчилгээний ажилтны харилцаа, эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ чанартай хүрч чадаж байгаа эсэх, талаарх санал асуулгад 79,3% сайн, 17,1% нь дунд, 3,6 % нь хангалтгүй үнэлгээ өгсөн байгаа нь байгууллагын үйл ажиллагаанд сэтгэл хангалуун байгааг харууллаа. |
| | | | Албан хаагчдад сар бүр олгох хоол, | Гүйцэтгэл-ээр | ажилтан албан хаагч 100% | 262,625,9 ₮ | 2019 оны жилийн эцсийн байдлаар 29,326,500 төгрөгийн унаа, хоолны зардалд 233,299,400 олгосон байна. /давхардсан тоогоор 318 ажилтан албан хаагчдад/ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | унааны зардлыг нэмэгдүүлэх | | | | |
| | 5 | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьд-чилан сэргийлэх | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг | Жилд 1-ээс доошгүй удаа | 1 удаа | 8,142,5 ₮ | НҮГ-ын ажилтан, алба хаагчид 2019 оны 5 дугаар сард Чингэлтэй дүүргийн эрүүл мэндийн нэгдэлтэй хамтран эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 231 ажилтан, албан хаагч хамрагдсан байна. |
| | | | Албан хаагчдын хамрагдалт | 100 хувь | 90,2 % | | Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт нийт ажилтан албан хаагчдын 90,2 хувь нь хамрагдсан. |
| | **Хэсгийн дундаж:** | | | | **95,5 %** | **885,861,5 ₮** | |
| **Үнэлгээний дундаж хувь:** | | | | | **94,5 %** | **889,161,5 ₮** | |

ТАНИЛЦСАН:
ЗАХИРГАА,САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА Ч.ШИНЭЧИМЭГ

ХЯНАСАН :
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН Т.ИТГЭЛ

БОЛОВСРУУЛСАН:
ЗАХИРГААНЫ АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН Г.ЭНХТУЯА